

# ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Эми Чой  
2024 оны 3 дугаар улирал



## МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн **Эми Чой** миний бие: (i) Компанийн тухай хууль (“КТХ”), Банкны тухай хууль (“БТХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: 2024 оны 3 дугаар улирал (“Тайлант хугацаа”).

### 1. ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-т заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Тайлант хугацаан дахь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2024 оны 7 дугаар сарын 08-16</li> <li>2024 оны 8 дугаар сарын 21</li> <li>2024 оны 8 дугаар сарын 28- 9 дүгээр сарын 9</li> <li>2024 оны 9 дүгээр сарын 4-9</li> <li>2024 оны 9 дүгээр сарын 5-11</li> <li>2024 оны 9 дүгээр сарын 30</li> </ul>
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал (“АХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2024 оны 8 дугаар сарын 21</li> <li>2024 оны 9 дүгээр сарын 30</li> </ul>
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал (“ЭУХ”), цахим санал хураалт	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2024 оны 8 дугаар сарын 21</li> <li>2024 оны 9 дүгээр сарын 5-11 цахим санал хураалт</li> </ul>
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшуулын хорооны хурал (“ЗНДЦУХ”)	Хорооны гишүүнээр	<ul style="list-style-type: none"> <li>2024 оны 8 дугаар сарын 21</li> </ul>

### 1.1 ТУЗ-ИЙН ХУРЛУУД

1.1.1 ТУЗ-ийн ээлжит хурал 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

- Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах
- ТУЗ-ийн өмнөх хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын тайлан:  
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (ЗНДЦУХ)

- Аудитын хороо (АХ)  
Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ)
4. Удирдлагын тайлан: (2024 оны 7 дугаар сарын байдлаар)
    - Сонгууль болон улс төрийн байдлын мэдээлэл
    - Үйл ажиллагааны явцын мэдээлэл
    - Эдийн засаг, банкны салбарын явцын мэдээлэл
    - Бизнесийн чиглэлийн гүйцэтгэл
    - Санхүүгийн үзүүлэлтүүд
  5. Монголын хөрөнгийн зах зээл: өнөөгийн байдал, ирээдүйн боломж, сорилт болон ХасБанкинд үзүүлэх нөлөө
  6. Хувьцааг эргүүлэн худалдаж авах хөтөлбөр
  7. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлэх дараагийн алхмуудын явцын мэдээлэл
  8. Стратегийн хэлэлцүүлэг: [REDACTED]
  9. Мэдээллийн технологи, цахим шилжилтийн явцын мэдээлэл
  10. Бусад

Хэлэлцсэн асуудал #1 Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #3 Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (ЗНДЦУХ), Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлогыг батлах шийдвэрийг миний зүгээс дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #3 Аудитын хороо (АХ), Чанарын хөндлөнгийн үнэлгээ/дутагдлын үнэлгээ хийх үйлчилгээг Дотоод аудиторуудын институтаар хийлгэх саналыг батлах шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #3 Эрсдэлийн удирдлагын хороо (ЭУХ), [REDACTED] тооцохдоо [REDACTED] болгох, мөн 2024 оны 2 дугаар улирлын холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй 6-н хэлцлийг батламжлах шийдвэрүүдийг миний бие дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #6 Хувьцааг эргүүлэн худалдаж авах хөтөлбөр, хөтөлбөрийн зорилго/механизм /шалгуур үзүүлэлтүүдийн талаар ТУЗ удаан хэлэлцсэний эцэст баталсан. Миний бие хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #8 Стратегийн хэлэлцүүлэг: [REDACTED] Миний зүгээс [REDACTED] талаар лавласан. Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал албан ёсны тоон мэдээлэл байхгүй ч [REDACTED] хэмээн хариулсан. Миний зүгээс [REDACTED] санал болгосон.

Хэлэлцсэн асуудал #9 Цахим шилжилт, мэдээллийн технологийн явцын мэдээллийн хувьд, Миний зүгээс [REDACTED] талаар дурдсан. ХасБанкны [REDACTED]

\_\_\_\_\_ мөн тодруулсан. Мэдээллийн технологи хариуцсан захирал хариулахдаа, \_\_\_\_\_ нь асуудал биш гэв.

### 1.1.2 ТУЗ-ийн ээлжит бус хурал

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр хуралдаж, хурлаар дараах асуудлыг хэлэлцэв:
  1. Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах
  2. ХасБанкны 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар гаргасан хагас жилийн санхүүгийн тайланг батлах тухай
  3. Бусад

Хэлэлцсэн асуудал #1: Хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #2: Хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

- Хүснэгт 2-т заасан дараах ТУЗ-ийн цахим санал хураалтын хуралд оролцсон.

### Тайлант хугацаан дахь ТУЗ-ийн цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурал	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. а) ХасБанкны Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэх б) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”) -ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай 2. Тэтгэврийн нэрийн дансны ерөнхий журмыг Ажилтны урт хугацаат хуримтлалын хөтөлбөрийн ерөнхий журам нэртэйгээр шинэчлэн батлах тухай	2024 оны 7 дугаар сарын 8-16
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. ХасБанк ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны хурлын хуваарийг батлах тухай	2024 оны 8 дугаар сарын 28- 9 дүгээр сарын 9
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”) -ын үр дүнг хүлээн зөвшөөрч, батлах тухай	2024 оны 9 дүгээр сарын 4-9
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. ХасБанкны эрх бүхий албан тушаалтанд олгох зээл (зээлийн карт сунгах) хэлцэл (“Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл”)	2024 оны 9 дүгээр сарын 5-11

Миний зүгээс Хүснэгт 2-т дурдсан цахим санал хураалтын хурлын бүх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

### 1.2 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛ (“АХ” )

Хүснэгт 3-т заасан дараах АХ-ны хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь АХ-ны хурлууд

Хүснэгт 3

Огноо	Хэлэлцсэн асуудал
2024 оны 8 дугаар сарын 21	<ol style="list-style-type: none"> <li>1. Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах</li> <li>2. Чанарын хөндлөнгийн үнэлгээ/дутагдлын үнэлгээ хийх үйлчилгээг Дотоод аудиторуудын институтаар хийлгэх санал</li> <li>3. Аудитын тайлан               <ol style="list-style-type: none"> <li>3.1 Аудитын явцын тайлан 2024 оны 2-р улирлын байдлаар</li> <li>3.2 2024 оны аудитын спринт тайлан- Цикл 3, 4                   <ol style="list-style-type: none"> <li>А. Зээлийн эх үүсвэрийн аудит (Улаанбаатар дахь салбарууд)</li> <li>Б. Мэдээллийн технологи- Тасралтгүй байдлын удирдлага</li> </ol> </li> <li>3.3 Газар дээрх аудитын тайлан</li> </ol> </li> <li>4. Аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</li> <li>5. Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (МонголБанкны журам)</li> <li>6. Бусад</li> </ol>
2024 оны 9 дүгээр сарын 30	<ol style="list-style-type: none"> <li>1. Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах</li> <li>2. Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийн хийсэн хагас жилийн тайлан</li> <li>3. Бусад</li> </ol>

8 дугаар сарын 21-ний өдрийн хурлын хэлэлцсэн асуудал #1 Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах шийдвэрийг миний зүгээс дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

8 дугаар сарын 21-ний өдрийн хурлын хэлэлцсэн асуудал #2 Чанарын хөндлөнгийн үнэлгээ/дутагдлын үнэлгээ хийх үйлчилгээг Дотоод аудиторуудын институтаар хийлгэх саналыг баталсан шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

8 дугаар сарын 21-ний өдрийн хурлын хэлэлцсэн асуудал #3.2а Зээлийн эх үүсвэрийн аудит, Миний зүгээс [REDACTED]

[REDACTED] хэлсэн. Ерөнхий аудитор [REDACTED]  
 [REDACTED] гэв. [REDACTED]  
 [REDACTED]

9 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын хэлэлцсэн асуудал #1 Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах шийдвэрийг миний зүгээс дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

9 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын хэлэлцсэн асуудал #2 Миний зүгээс [REDACTED]

[REDACTED] лавласан. Гүйцэтгэх захирал үүнд хариулахдаа, [REDACTED]  
 [REDACTED] гэв. Хагас жилийн санхүүгийн тайлангийн тодруулгад хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцүүлж [REDACTED] гаргаж буй банкны хүчин чармайлтыг дурдахыг би санал болгов. АХ-ны зүгээс Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-ийн хийсэн хагас жилийн тайланг тодруулгад завсар оруулсан байдлаар батлахыг ТУЗ-д санал болгосон. Хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

**1.3 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЭУХ” )**

Хүснэгт 4-т заасан дараах ЭУХ-ны хуралд оролцсон.

**Тайлант хугацаан дахь ЭУХ-ны хурлууд****Хүснэгт 4**

Огноо	Хэлэлцсэн асуудал
2024 оны 8 дугаар сарын 21	<ol style="list-style-type: none"><li>Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах</li><li>ХасБанкны эрсдэлийн тайлан 2024 оны 7 дугаар сарын байдлаар</li><li>Кибер аюулгүй байдлын тайлан (2024 оны 7 дугаар сарын байдлаар)</li><li>Хянан нийцүүлэлтийн явцын мэдээ/тайлан (2024 оны 7 дугаар сарын байдлаар)</li><li>2024 оны 2 дугаар улиралд хийсэн холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлах</li><li>Бусад</li></ol>
2024 оны 9 дүгээр сарын 5-11	<ol style="list-style-type: none"><li>ХасБанкны эрх бүхий албан тушаалтанд олгох зээл (зээлийн карт сунгах) хэлцэл (“Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл”)</li></ol>

8 дугаар сарын 21-ний өдрийн ЭУХ-ны хурлын хэлэлцсэн асуудал #1 Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

8 дугаар сарын 21-ний өдрийн ЭУХ-ны хурлын хэлэлцсэн асуудал #2 Эрсдэлийн тайлан, [REDACTED] тооцохдоо [REDACTED] баталсан, миний бие хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

8 дугаар сарын 21-ний өдрийн ЭУХ-ны хурлын хэлэлцсэн асуудал #3 Кибер аюулгүй байдлын тайлан, Миний зүгээс [REDACTED] байгааг дурдав. [REDACTED] саналыг хэлсэн. Түүнчлэн, [REDACTED].

8 дугаар сарын 21-ний өдрийн ЭУХ-ны хурлын хэлэлцсэн асуудал #5 2024 оны 2 дугаар улиралд хийсэн холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжлах, 6-н холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батламжилсан. Дээрх хурлын шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

ЭУХ-ны цахим санал хураалтын хурлын хэлэлцсэн асуудал #1, ХасБанкны эрх бүхий албан тушаалтанд олгох зээлийг баталсан бөгөөд хурлын шийдвэртэй зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

**1.4 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЗНДЦУХ” )**

Хүснэгт 5-т заасан дараах ЗНДЦУХ-ны хуралд оролцсон.

## Тайлант хугацаан дахь ЗНДЦУХ-ны хурлууд

Хүснэгт 5

Огноо	Хэлэлцсэн асуудал
2024 оны 8 дугаар сарын 21	<ol style="list-style-type: none"><li>Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах</li><li>Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлого (Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн Засаглалын Кодексийн дагуу)</li><li>Монголбанкны компанийн зохистой засаглалын жилийн үнэлгээний тухай</li><li>Бусад</li></ol>

Хэлэлцсэн асуудал #1 Хурлаар хэлэлцэх асуудлыг батлах шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #2 Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлогыг батлах шийдвэрийг дэмжсэн бөгөөд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #3 Миний зүгээс ХасБанкны зохистой засаглалын үнэлгээний түрүү үеийн оноонуудын талаар лавласан бөгөөд Монголбанкны журмын дагуу тогтмол дээш оноог авч, дөрвөн шатлалт үнэлгээний системийн дээд шатлал “удирдлагын үйл ажиллагаа нь хэвийн” ангилалд багтсанд баяртай байв.

### 1.5 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ (“ХЭЭБХ”) 2024 ОНЫ 7 ДУГААР САРЫН 25- 9 ДҮГЭЭР САРЫН 04, ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ХЭЛБЭРЭЭР ЦАХИМААР

Банкны 2024 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг зарлан хуваарилах эсэх асуудлаар ХЭЭБХ эчнээ санал хураалтын хэлбэрээр цахимаар зохион байгуулагдсан тул ТУЗ-ийн гишүүд оролцох шаардлагагүй байсан.

### 2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд, ТУЗ-ийн хурлаар 2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр 1 (нэг) сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталсан. Миний бие энэхүү хэлцэлд оролцож, саналаа өгч ажилласан.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

### 3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь

Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалыг дүгнэхэд:

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ	
КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5  (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)	ТУЗ болон удирдлагын баг хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд нарийн зүйлүүдийг анхаарч авч үзэн бүх хүчин чармайлтаа гаргаж, ажигладаг болохыг ажигласан.
КтХ 79.3.2  (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)	ТУЗ болон удирдлагын баг үүргээ хангалттай хэмжээнд ил тод гүйцэтгэж байгааг би ажигласан. Анхаарал татахуйц ямар нэгэн асуудал ажиглагдаагүй.
КтХ 79.3.3  (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ)	ХЭЭБХ эчнээ санал хураалтын хэлбэрээр цахимаар 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс 9 дүгээр сарын 4-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1  (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын багийн гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт нийцэж байгааг ажигласан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2  (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын баг бүх цаг үед холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, хичээн ажиллаж байсныг ажигласан.



<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3</b>  (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)	ТУЗ болон удирдлагын багийн зүгээс банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн аливаа үйлдэл, шийдвэр гаргаагүй.
<b>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6</b>  (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)	Мэдээлэх ямар ч асуудал ажиглагдаагүй болно.

#### 4. БУСАД

Удирдлагын баг ТУЗ-ийн 8 дугаар сарын хурлын дараа ТУЗ-ийн гишүүдийг Лизингийн VIP салбараар зочлох ажлыг зохион байгуулсан. Бид Лизингийн салбарын захирал болон багийнхантай нь уулзав. Харилцагчдад хамгийн сайн цогц санхүүгийн үйлчилгээг үзүүлэхийн тулд бизнесийн сегмент [REDACTED] санал болгож буй баг хамт олны гайхалтай уур амьсгал, банкны өндөр гүйцэтгэлд зорьж буй ажилчдын эерэг хандлагыг ажигласандаа би баяртай байсан.

Огноо: 2024 оны 10 дугаар сарын 8

Гарын үсэг: Эми Чой